



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтүмэн сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2026/027/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: С.Энхбаатар Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatarsu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 184

танай _____-ны № _____-т

БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.ГУНГААЦЭРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Баянтүмэн сумын Засаг дарга 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээ үнэлүүлж дүгнүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залилангийн шинж чанартай зөрчилтэй асуудал нь хууль, хяналтын байгууллагад хянагдаж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2126050072

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	120,941,864.64	36,816,104.64
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	120,941,864.64	36,816,104.64
3121	Төгрөг	120,941,864.64	36,816,104.64
31211	Төрийн сангийн харилцах	120,941,864.64	36,816,104.64
33	АВЛАГА	132,291,314.00	221,016,219.00
33500	Бусад авлага	0.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага		221,016,219.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	132,291,314.00	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	253,233,178.64	257,832,323.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	253,233,178.64	257,832,323.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	253,233,178.64	257,832,323.64
512	Хуримтлагдсан үр дүн	253,233,178.64	257,832,323.64
51210	Өмнөх үеийн үр дүн	245,693,341.44	253,233,178.64
51220	Тайлант үеийн үр дүн	7,539,837.20	4,599,145.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	253,233,178.64	257,832,323.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	253,233,178.64	257,832,323.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	6,600,845.92	4,749,145.00
1200	Нийтлэг татварын бус орлого	6,600,845.92	4,749,145.00
120002	Хүүгийн орлого		4,749,145.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	6,600,845.92	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,600,845.92	4,749,145.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,440,515.80	150,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,515.80	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,515.80	150,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,515.80	150,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,440,515.80	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,160,330.12	4,599,145.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,160,330.12	4,599,145.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	6,600,845.92	21,024,240.00
1200	Нийтлэг татварын бус орлого	6,600,845.92	21,024,240.00
120002	Хүүгийн орлого	0.00	4,749,145.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,600,845.92	16,275,095.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	6,600,845.92	16,275,095.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,600,845.92	21,024,240.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,440,515.80	150,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,515.80	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,515.80	150,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,515.80	150,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	1,440,515.80	150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,160,330.12	20,874,240.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	105,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	105,000,000.00
223001	Бусад хөрөнгө		105,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	105,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-105,000,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,160,330.12	-84,125,760.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,641,404.44	120,941,864.64
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89,801,734.56	36,816,104.64

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	253,233,178.64	253,233,178.64
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	253,233,178.64	253,233,178.64
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,599,145.00	4,599,145.00
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	257,832,323.64	257,832,323.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,749,145.00	4,749,145.00
122002	Хандив тусламж /гадаад/	4,749,145.00	4,749,145.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,557,200.00	0.00
132004	Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/	93,557,200.00	0.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	98,306,345.00	4,749,145.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,021,000.00	150,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,021,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,021,000.00	150,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,021,000.00	150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,500,000.00	105,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	130,500,000.00	105,000,000.00
223001	Бусад хөрөнгө	130,500,000.00	105,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	132,521,000.00	105,150,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	120,941,864.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,963,800.00	16,275,095.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 83.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 19.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 64.8 сая төгрөгийн 1 албан шаардлага өгч ажиллалаа.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хувийн дансанд орсон сангийн зээлийн төлбөрийг сангийн дансанд төвлөрүүлээгүй	1	19,100.0	1	19,100.0								
Зээлийн графикт хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй	1	64,825.0			1	64,825.0						
Дүн	2	83,925.0	1	19,100.0	1	64,825.0						

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.